

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРААС  
2020 ОНЫ 11 ДҮГЭЭР САРД ХЭРЭГЖҮҮЛСЭН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 оны 12 дугаар сарын 03

Улаанбаатар хот

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Харьяатын тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, журмын дагуу 2020 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

### НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

#### 1.1. Виз, зөвшөөрөл, бүртгэлийн чиглэлээр

Тайлант хугацаанд байгууллагын төвд түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг уригч төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн нийт 143 гадаадын иргэнд визийн зөвшөөрөл олгож, 103 гадаадын иргэний визийн зөвшөөрлийг Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газарт, 28 гадаадын иргэний визийн зөвшөөрлийг хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдэд цахимаар болон факсаар тус тус илгээсэн байна.

Цахим хэлбэртэй “Монгол Улсад оршин суух үнэмлэх” 293 шинээр хэвлэж, 363 цахим үнэмлэхний хүчинтэй хугацааг сунгаж, 104 цахим үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийсэн байна.

Уригч 24 аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хүсэлтийн дагуу 24 гадаадын иргэний виз, бүртгэлийн талаарх тодорхойлолт олгон, оршин суух зөвшөөрөл авах, сунгуулах хүсэлт гаргасан 25 гадаадын иргэний хүсэлтийг байгууллагын даргын тушаалаар шийдвэрлэсэн.


Мөн 16 иргэний хувийн хэрэгт баяжилт хийн, нийт 16 иргэний мэдээллийг цахим архивт оруулж, гадаадын 1 иргэнд шинээр регистрийн дугаар олгов.

Байгууллагын төв болон орон нутаг дахь нэгжүүдэд гадаадын иргэн, харьяалалгүй хүн, уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дараах үйлчилгээг үзүүлсэн байна. Үүнд:

110 гадаадын иргэнд зохих ангиллын визийг олгож, Монгол Улсад 90 хүртэл хоногийн визтэй ирсэн, мөн визгүй зорчдог түр ирэгч гадаадын иргэдээс тус улсад байх хугацааг сунгуулах хүсэлтийг хянан 38 гадаадын иргэний байх хугацааг 30 хүртэл хоногоор сунгасан.

Холбогдох төрийн захиргааны байгууллагуудын зөвшөөрлийг үндэслэн 200 гадаадын иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгож, гадаадын 285 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган оршин суух зөвшөөрөлтэй 108 гадаадын иргэний бүртгэлд хасалт хийсэн. Оршин суугаа хэлбэр нь өөрчлөгдсөн 6 гадаадын иргэний визийн ангилал солив.

Монгол Улсад түр ирэгчээр ирсэн гадаадын 33 иргэнийг бүртгэж, нутаг буцсан, статус өөрчлөгдсөн гадаадын 96 иргэний бүртгэлд хасалт хийсэн.



2020 оны 11 дүгээр сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 82.6 хувиар, виз олголт 93.9 хувиар, хувийн урилга олголт нэг дахин, оршин суух зөвшөөрөл олголт 65.1 хувиар, оршин суух зөвшөөрлийн хасалт 96 хувиар, түр ирэгчийн бүртгэл 97.9 хувиар, түр ирэгчийн хасалт 94.6 хувиар, визийн сунгалт 60 хувиар тус тус буурсан байна. Үйл ажиллагааны үзүүлэлтийн энэ бууралт нь “КОВИД 19” гоц халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор Засгийн газар болон Улсын онцгой комиссын шийдвэрээр гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж хилийн боомтоор нэвтрэх зорчигчийн хөдөлгөөнийг түр зогсоосонтой холбоотой юм.


1.2. Иргэний харьяалал, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын чиглэлээр:

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан БНХАУ-1, БНЭУ-1, нийт 2 иргэний хүсэлт, баримт бичгийг шинээр хүлээн авсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 10 дугаар сарын 30, 11 дүгээр сарын 05-ны өдрийн 132, 133 дугаар зарлигаар БНКаЗУ-ын харьяат болох 8, Япон улсын харьяат болох 1, нийт 9 иргэн Монгол Улсын харьяатаас гарсан.

Монгол Улсын харьяатаас гарч БНСУ-ын харьяат болох хүсэлт гаргасан 3 иргэний хүсэлт, баримт бичгийг шинээр хүлээн авч, БНАвстриУ-ын харьяат болох 1, ХБНГУ-ын харьяат болох 18, БНСУ-ын харьяат болох 19, БНАвстриУ-ын харьяат болох 5, БНХАУ/Тайвань/ харьяат болох 1, нийт 32 иргэний хүсэлтэд санал авахаар холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

Мөн хоёрдмол харьяалал үүсгэсэн 6 иргэнийг шинээр бүртгэж мэдээллийн санд оруулсан ба нийт 3801 иргэн бүртгэлтэй байна.



Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа эрхлэх 1, зөвшөөрлийн хугацаагаа сунгуулах 1, нийт 2 байгууллагын хүсэлтийг хүлээн авч, БНИТалиУ-ын игэнд үрчлэгдсэн 1 хүүхдийн тайланг хүлээн авч мэдээллийн санд бүртгэсэн.

Мөн 11 дүгээр сарын 06-ны өдөр “Холт-Интернэйшнл” төрийн бус байгууллагын төлөөлөгчидтэй байгууллагын дарга Н.Ууганбаяр, холбогдох албан хаагчдын хамтаар уулзалт хийж, санал солилцсон.

### 1.3. Хяналт шалгалт, албадан гаргах ажиллагааны чиглэлээр:

Тайлант хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн 4 улсын 7 гадаадын иргэнийг байгууллагын даргын 4 удаагийн тушаалаар тус улсаас албадан гаргасан ба мэдээллийг холбогдох газруудад албан бичгээр хүргүүлэх ажлыг зохион байгуулав.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр байгууллагын даргын 3 удаагийн тушаалаар гадаадын 3 улсын 8 иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлж, 1 удаагийн тушаалаар гадаадын 1 улсын 1 иргэний гарахыг түдгэлзүүлсэн шийдвэрийг хүчингүй болгосон байна.

Тайлант хугацаанд 1 удаагийн төлөвлөгөөт, 38 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 72 аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын 70 иргэнийг хамруулсан ба 9 гадаадын иргэн, 6 аж ахуйн нэгж, байгууллага /гадаадын 10 иргэн/-д Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулж, 11,860,000 /арван нэгэн сая найман зуун жаран мянга/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүллээ.



2020 оны 11 дүгээр сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 95.3 хувиар, уригч хуулийн этгээд

96.5 хувиар, албадан гаргагдсан гадаадын иргэн 99.2 хувиар тус тус буурсан, харин гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн 75 хувиар өссөн байна.

## ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

### 2.1. Захиргаа, удирдлагын чиглэлээр:

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлтэд хяналт тавин, хэрэгжилтийг бэлтгэн 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 01/... дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн даргад хүргүүлэн, байгууллагын дарга 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн сайдын шуурхай хуралд оролцов.

Дэлхийн банкны “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл”-ийн санхүүжилтээр Сангийн яаманд хэрэгжиж буй 2020 оны 11 дүгээр 18,19-ний өдрүүдэд зохион байгуулагдах сургалтад тус байгууллагаас суралцах албан хаагчдын нэрсийг 2020 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 03/1675 дугаар тоот албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн захиргаа удирдлагын газрын дарга Г.Мөнхцэцэгт хүргүүлсэн.

Байгууллагын даргын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/253 тоот тушаалаар Коронавируст халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх дэд даргаар ахлуулсан 7 гишүүний бүрэлдхүүнтэй “Гамшгаас хамгаалах түр штаб” байгуулан арга хэмжээг шуурхай зохион байгуулан ажиллаж байна. Үүнд: Коронавируст халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын нийт 3 чиглэлээр 24 арга хэмжээ, 13 хавсралт бүхий төлөвлөгөө болон 6 үүрэг, чиглэл бүхий 10 дугаар албан даалгавар боловсруулан баталж төв болон орон нутгийн зохион байгуулалтын нэгжийн дарга нарт хүргүүлж ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 181 дүгээр тогтоол, Улсын Онцгой Комиссоос өгсөн үүрэг, чиглэлийн дагуу гэрээсээ цахимаар ажиллах болон ажлын байранд ажиллах албан хаагчдын хуваарийг батлан, нийт албан хаагчдын 10-15 хувийг батлагдсан хуваарийн дагуу ээлжлэн ажиллуулж байна.

Мөн Коронавируст халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх шуурхай штабын тусгаарлах байрыг бэлтгэж, шаардагдах баримт бичиг, хувцас хэрэглэл, бараа, материалыг байршуулан тоноглож, хуваарийн дагуу ажилласан 16 албан хаагчид витамин С, чацаргана үрэл, 2000 ЕД витамин Д тараан өгсөн. Мөн “Эко ахуй” ХХК-аар 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр байгууллагын бүх өрөө тасалгаа спорт заал, авто гарааж, архив, хонгилуудад ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэсэн.

Бүх нийтийн бэлэн байдлын үед ээлжээр ажиллах албан хаагчдын хувийн болон албаны автомашины замын хөдөлгөөнд оролцох тусгай зөвшөөрлийг байгууллагын даргын 11 дүгээр сарын 23-ны өдрийн 01/1753 дугаар албан бичгээр Нийслэлийн онцгой комисст хүргүүлж нийт 34 авто машинд замын хөдөлгөөнд оролцох зөвшөөрөл авсан.

Байгууллагад нэвтэрч буй иргэд албан хаагчдын халууныг үзэх бүртгэх албан хаагчид болон халдвар хамгааллын хувцас хэрэглэлтэй ажиллах, журам сахиулах томилгоот шуурхай бүлгүүдийн ажиллах зааварчилгааг боловсруулсан.

Монгол улсын засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 178 дугаар тогтоол, УОК-ын даргын 20 дугаар тушаал, 32 дугаар хурлын тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг зохих загварын дагуу боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд цахимаар хүргүүлсэн.

Албан хаагчаас ирүүлсэн өргөдөл, байгууллагын дарга, болон нэгжийн даргаас өгсөн үүргийн дагуу 2 албан хаагчид дотоод хяналт шалгалтын ажиллагаа хийж байгууллагын даргад илтгэх хуудсаар танилцуулсан

Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2020 оны төлөвлөгөөний дагуу давхардсан тоогоор төрийн үйлчилгээний 34 албан хаагчид ур чадварын цалингийн 10-25 хувийн нэмэгдэл олгож, “Хөдөлмөрийн дотоод журам”-ын дагуу 3 албан хаагчид нийт 520.000 мянган төгрөгийн тусламж олгосон. Мөн хилийн боомт орон нутаг ажилласан таван жилийн урамшууллыг 1 албан хаагчид олгож, 2020 оны ээлжийн амралтын хуваарийн дагуу 5 албан хаагчид ээлжийн амралтын хуудсыг бичиж Санхүү, хангалт, үйлчилгээний газарт хүлээлгэн өгсөн.

Тайлант хугацаанд төрийн захиргаанд 3 албан хаагч түр томилогдож, өөрийн хүсэлтээр төрийн захиргааны 1 албан хаагч, гэрээт 3 ажилтан чөлөөлөгдөв

Улаанбаатар хотын замын түгжрэл, байгууллагын төв байр хотын төвөөс алслагдмал байрладаг зэргээс шалтгаалан ажлын цагийн хуваарьт өөрчлөлт оруулах санал асуулгыг нийт албан хаагчдаас авч, ажлын эхлэх цагийг 08:00 цаг, дуусах цагийг 16:30 цаг болгох саналыг дэмжин, байгууллагын даргын 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/263 дугаар тушаалаар Хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт оруулан 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэх болсоныг нийт албан хаагчдад цахимаар мэдэгдэв.

Төрийн албаны зөвлөлөөс 2020 оны 11 дүгээр сарын 04-09-ний өдрүүдэд орон даяар зохион байгуулсан “Төрийн албаны ерөнхий шалгалт”-д тус байгууллагын төвийн зохион байгуулалтын нэгжээс 15, орон нутаг дахь зохион байгуулалтын нэгжээс 3 албан хаагч хамрагдсаны 7 буюу 38.8 хувь нь тэнцсэн.

“УИХ-ын төрийн байгуулалтын ёс зүй, сахилга хариуцлагын болон инноваци, цахим бодлогын байнгын хороодын дарга нараас өгсөн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн чиглэлд үндэслэн, зохион байгуулалтын нэгжүүдээс санал авч боловсруулан, байгууллагын дарга 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр батлав..

Байгууллагын дэргэдэх Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг нөхөн сонгох санал асуулгын дүнг нэгтгэн илтгэх хуудсаар удирдлагад танилцуулсан.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой 6 мэдээ, мэдээлэл бэлтгэж, 6 телевиз, 5 сонин, 69 сайтад (давхардсан тоогоор) нийтлүүлэв. Тухайлбал, “БНХАУ-ын 33 иргэнийг Монгол улсаас албадан гаргалаа” мэдээ TV9, NTV, NTN, VTV зэрэг 6 телевиз, news.mn, gogo.mn, montsame.mn, zaluucom.mn, eguur.mn, asu.mn, isee.mn зэрэг 36 сайтад, “Виз, оршин суух зөвшөөрлийн хугацаа дуусч буй гадаадын иргэдийн холбогдох хүсэлтийг цахимаар хүлээн авч байна” мэдээ zaluucom.mn, news.mn, 24tsag.mn, mnb.mn, newswall.mn зэрэг 15 сайтад, “ГИХГ-ын “Онлайн туслах” ажиллаж эхэллээ” zindaa.mn, shuud.mn, ontslokh.mn, montsame.mn 8 сайтад, “Ажлын цагийн хуваарьт өөрчлөлт орлоо”

мэдээ undesten.mn, olnodo.mn, zindaa.mn, montsame.mn зэрэг 5 сайтад тус тус нийглэгдсэн.

Мөн 11 дүгээр сарын 9-ны өдөр МҮОНТ-ийн “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлэгт “Гадаадын иргэдийн виз, бүртгэл, хяналтын асуудал” сэдвийн хүрээнд зарим албан хаагчид оролцон мэдээлэл, ярилцлага өгөв.

Байгууллагын цахим хуудаст байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 11 мэдээлэл, гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эрүүл мэндийн зөвлөмж, зөвлөгөө бүхий 16 мэдээлэл, албан хаагчдад зориулан хамт олны эерэг уур амьсгалыг хэрхэн бүрдүүлэх тухай 5, гэр бүлд зориулсан 1 зурагт хуудас бүхий зөвлөмжүүдийг бэлтгэн албан хаагчдад мэдээлсэн.

Байгууллагын үйл ажиллагаа, үндсэн чиг үүрэг, албан хаагчидтай холбогдох мэдээллийг олон нийтийн цахим сүлжээнд өдөр бүр хайлт хийн, хяналт тавьж “Нийслэлээс 300 км-ийн зайд хятадууд олборлолт явуулж байна” мэдээ eepnews.mn сайтад, “Өвөрмонгол иргэн Балжиннямыг улсаасаа албадан гаргавал түүнд тэмцэл өдүүлсэн хэрэг тулгаж, цаазаар авахыг ч үгүйсгэхгүй” гарчигтай ярилцлага “Өдрийн сонин”-ны 11 сарын 25-ны өдрийн дугаарт, мөн unen.mn, dnn.mn сайтад нийтлэгдсэнийг олж удирдлагад танилцуулан, нийгмийн сүлжээнд гарсан мэдээллийг архив үүсгэн хадгалсан.

Холбогдох зөвшөөрлийн дагуу 19 ажилтан, алба хаагчид 219 хадгаламжийн нэгжийг ашиглалтад олгож, тухай бүр бүртгэл хөтөлж, ашиглалтын хуудас хөтлөж, 111 хуудас баримтыг “Хуулбар үнэн” тэмдгээр баталгаажуулж, Монгол Улсын иргэний харьяалалтай холбогдох 9 хадгаламжийн нэгжийн 2159 хуудас баримтыг байгууллагын цахим архив программд холбов.

Байгууллагад ирсэн нийт 131 албан бичгийг удирдлагад танилцуулан бүртгэсэн. Үүнээс хариутай 52 албан бичиг, хариугүй 79 албан бичгийг холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн. Эдгээр хариутай албан бичгээс хугацаандаа шийдвэрлэгдсэн 35 албан бичиг, шийдвэрлэх шатандаа байгаа 17 албан бичиг байна. Мөн дотоодод 25 албан бичгийг бүртгэлийн дэвтэрт бүртгэн холбогдох алба хаагчдад хүлээлгэн өгч, 108 албан бичгийг албан хаагчдаас хүлээн авч, бүрдлийг шалгаж, 81 албан бичгийг шууданд хүлээлгэн өгч явуулсан. Байгууллага, аж ахуйн нэгжид гардаг зөрчилгүй тухай 13 тодорхойлолтод дугаар олгож, 4 тодорхойлолтыг хүлээлгэн өгөхөд бэлтгэсэн.

Тайлант хугацаанд байгууллагын даргын А тушаал-20, Б тушаал-15, албан даалгавар -1 гарсан байна.

Холбогдох журам, стандартын дагуу эмчийн анхан шатны тусламж үйлчилгээг 32 албан хаагчид үзүүлэн эмийн болон эмийн бус эмчилгээ хийж, бүртгэл хөтлөн ажилласан.

Байгууллагын “Сагсан бөмбөгийн аварга шалгаруулар тэмцээн”-ийг 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулсан. Үүнд эрэгтэй, эмэгтэй нийт 11 багийн 66 тамирчин оролцсон бөгөөд эрэгтэй 1-р байрыг Мэдээллийн технологийн хэлтэс, эмэгтэй 1-р байрыг Виз, зөвшөөрөл, харьяатын газрын баг тамирчид эзэлсэн.

Тайлант хугацаанд байгууллагын хэмжээнд 35 өргөдөл ирсэн бөгөөд гомдол ирээгүй. Үүнээс 21 өргөдөл байгууллагын төвд, 14 өргөдөл орон нутаг дахь нэгжүүдэд иржээ. Үүнээс 29 өргөдөл холбогдох хуулийн хугацаанд шийдвэрлэгдэж, 6 өргөдөл шийдвэрлэлтийн шатанд байна. Хуулийн хугацааг сунгасан болон хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй.

#### Өргөдөл гомдлын агуулга, бүтцийг хүснэгтээр

| №    | Албан хаагчдаас ирүүлсэн  | Тоо |
|------|---|-----|
| 1    | Чөлөө хүсэх /сунгах / тухай / эрүүл мэнд, хүүхэд асрах, бусад/      | 11  |
| 2    | Ажлаас чөлөөлөгдөх тухай  | 5   |
| 3    | Бусад   | 5   |
| Нийт |   | 21  |
| №    | Иргэд, байгууллагаас ирүүлсэн                                       | Тоо |
| 1    | Оршин суух болон визийн зөвшөөрөл олгох, сунгаж өгөхийг хүсэх тухай | 11  |
| 2    | Албадан гаргахаас чөлөөлүүлэх                                       | 1   |
| 3    | Гадаад иргэнийг шалгаж өгнө үү                                      | 1   |
| 4    | Тодорхойлолт хүсэх тухай  | 1   |
| Нийт |   | 14  |

#### 2.2. Эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажил хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Хууль зүйн байнгын хорооны Дэд ажлын хэсэгт байгууллагын холбогдох албан тушаалтнууд оролцож, хуулийн төсөлд холбогдох саналыг тухай бүр өгч ажиллав.

Тус хуулийн төслүүдийг УИХ-ын анхны хэлэлцүүлгээр 2020.11.19-нд хэлэлцэхээр тогтсон ч Covid-19 цар тахлын улмаас тодорхойгүй хугацаагаар хойшлов.

Нийтийн албанд шинээр томилогдох 2, шилжин томилогдох 1, албан дэвшин 1, нийт 4 албан хаагчийн холбогдох материалыг авч Авлигатай тэмцэх газарт хянуулахаар хүргүүлж, Монгол Улсын иргэн болох хүсэлт гаргагчтай хийсэн 2 удаагийн ярилцлагад оролцсон 9 албан тушаалтны /давхардсан тоогоор/ ашиг сонирхлын зөрчилгүйгээ илэрхийлсэн мэдэгдэл, тайлбарыг хүлээн авч бүртгэлийн систем /[meduuleg.iaac.mn/](http://meduuleg.iaac.mn/)-д мэдээллийг оруулсан.

Байгууллагын дарга Н.Ууганбаяр 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Доан Тхи Хыөнг, Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн дарга Ч.Тулгацоодол 2020 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр ОХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны атташе Аксёнов.О.В-г, 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр БНХАУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-ны консул Жия нарыг тус тус хүлээн авч уулзаж санал солилцов.

#### 2.3. Мэдээллийн технологийн чиглэлээр:

eVisa системийн нэмэлт хөгжүүлэлтийн хүрээнд тусгай хүсэлт хүлээн авах хэсгийг шинээр хийж 11 сарын 27-ны өдөр ажиллагаанд оруулсан бөгөөд 12

удаагийн хүсэлтийг хүлээн авсан бөгөөд тус системийг ДАН системтэй холбох албан бичгийг Үндсэний дата төв УТҮГ-т 11 сарын 3-ны өдөр явуулж сервер гаргахтай холбоотой оролт, гаралтын мэдээллийг хийж гүйцэтгэсэн.

Захиргаа, удирдлагын газрын хүсэлтийн дагуу Цахим архивын программ болон хүний нөөцийн систем /staffdb/- т холбогдох хөгжүүлэлтийг хийж, дизайн хэсгийг засварласан.

Эх бэлтгэл, хэвлэх ажлын хүрээнд А5 хэвлэл 110 ширхэг, А4 хэвлэл 300 ширхэг, А3 хэвлэл 100 ширхэгийг хэвлэж, ламинаторын үйлчилгээ 555 ширхэг, зурагт хуудас, эх бэлтгэлийн 12 ажлыг тус тус хийв.

#### 2.4. Санхүү, хөрөнгө оруулалт, хангалт үйлчилгээний чиглэлээр:

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын /төсвийн төвлөрүүлэн захирагч/ багцад Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу 2020 онд 7729.8 сая төгрөг батлагдсанаас Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулиар тодотгон бараа үйлчилгээний зардлаас 390.3 сая төгрөг хасагдаж 7339.5 төгрөгийн төсөв батлагдсан.

Энэ оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар өссөн дүнгээр 6,888.9 сая төгрөгийн зарцуулах эрх тавигдсанаас 5,546.3 сая төгрөг буюу 80%-ийн зардлын гүйцэтгэл гарч батлагдсан төсвийг зориулалтын дагуу зохих дүрэм, журамд нийцүүлэн анхан шатны баримтыг үндэслэн зарцуулав.

УИХ-аас 2020 оны төсвийн тодотголыг баталсантай холбогдуулан хэмнэгдэж байгаа зардлаас дутагдалтай байгаа зардлуудад гүйлгэн зарцуулах тооцооллыг хийж 11 дүгээр сарын төсвийн хуваарьт 2 дахь удаагаа өөрчлөлт оруулах болон 12 дугаар сарын төсвийн хуваарьд өөрчлөлт оруулах саналыг бүх харьяа газруудаас авч саналаа нэгтгэн боловсруулж дэлгэрэнгүй тайлбарын хамт Хууль зүй, дотоод хэргийн яаманд мэйлээр хүргүүлэн санхүүжилтийг бүрэн хүлээн авсан.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн 2020 оны 10 дугаар сарын мэдээг Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр хүргүүлсэн.

Шилэн дансны тухай хуульд заасны дагуу байгууллагын цахим хуудсанд 09 дүгээр сарын байдлаар төсвийн гүйцэтгэл хэсэгт оруулах мэдээлэл 21, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт хэсэгт оруулах мэдээлэл 21, бусад хэсэгт оруулах мэдээлэл 36 тус тус мэдээлж, байгууллагын “Б” байрны 3 давхарт байрлах шилэн дансны самбарт холбогдох мэдээллүүдийг шинэчлэн байршуулав.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Засгийн газрын 2003 оны 172 дугаар тогтоолын дагуу 2020 оны 11 дүгээр сарын байдлаар 1,030,0 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна. Холбогдох нэгжүүдтэй тэмдэгтийн хураамжийн тайлан, шийтгэлийн хуудасны тайлан, визийн хуудасны тайланг тус тус хийн, тооцоо нийлэв.

Сангийн сайдын 2019 оны 74 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын дагуу байгууллагын 2020 оны туслах



үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах тайлан, холбогдох материалыг бэлтгэн 2020 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 01/1651 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Байгууллагын 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, байгууллагын даргаар батлуулж, тус төлөвлөгөөний дагуу худалдан авалт хийх зөвшөөрлийн хүсэлтийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Байгууллагын 11 дүгээр сарын үйл ажиллагаанд үйлчлэх 7 автомашины 1 өдөрт зарцуулах шатахууны нормыг сараар батлуулан жолооч нарт олгож өдөр тутам хяналт тавин, 1 сантехникч ажлын өдрүүдэд ажлын цагаар байгууллагын сантехникийн бүрэн бүтэн байдлыг хариуцан ажиллаж байна.

#### 2.5. Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн чиглэлээр:

Байгууллагын үйл ажиллагааны мэдээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд 01/1676, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөхөд 01/1678, байгууллагын статистик мэдээг Хууль зүй, дотоод хэргийн яаманд 01/1677 дугаар албан бичгээр 2020 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр тус тус хүргүүлэн ажилласан.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас энэ оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 7/1324 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-д заасан өөрийн байгууллагад хамаарах мэдээллийг хугацаанд нь хүргүүлж байхыг анхаарах тухай албан бичгийн мөрөөр холбогдох арга хэмжээг авч, дүнг 11 дүгээр сарын 05-ны өдөр, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, соёл, нээлттэй байдлын талаар албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааг авч, нэгтгэн үр дүнг 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр, Зүүн бүс дэх газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитын шалгалтыг хийж гүйцэтгэн, үр дүнг 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр тус тус илтгэх хуудсаар байгууллагын даргад танилцуулан ажиллав.

Мөн 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн хяналт, шалгалтаар өгсөн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтэд 2020 оны 11 дүгээр сарын 16, 17-ний өдрүүдэд хяналт тавьж ажиллалаа. Уг шалгалтаар байгууллагын хэмжээнд “Зөрчилгүй санал, дүгнэлт” авсан бөгөөд нийт 106.2 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 38.0 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 68.2 сая төгрөгийн зөрчилд 9 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилтийг төв болон орон нутаг дахь нэгжүүдээс авч хэрэгжилтэд хяналт тавихад байгууллагын хэмжээнд албан шаардлагын хэрэгжилт 100%, зөвлөмжийн хэрэгжилт 97%, хэрэгжилт дунджаар 95.7% байсан.

Байгууллагын даргын энэ оны 01, 03, 04 дүгээр албан даалгаврын 3 дугаар улирлын хэрэгжилтийг хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдээс хүлээн авч, нэгтгэн 2020 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн болно.

“Хилийн зарим боомтын талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 172 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын мөн оны 05, 06 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлээр орон нутаг дахь газруудад

2020 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр чиглэл хүргүүлж, дээрх албан даалгаврын биелэлтийг орон нутаг дахь газруудаас авч, нэгтгэн долоо хоног бүрийн Баасан гараг бүрд Улсын онцгой комиссын Ажлын албанд албан бичгээр болон [uok.nema.gov.mn](http://uok.nema.gov.mn) цахим хаягаар хүргүүлэн ажиллав..

ДАРГА

Н.УУГАНБАЯР

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ДАРГА

Д.ДАВААНЯМ

НЭГТГЭСЭН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

М.ЭРДЭНЭБАТ

О.ОДГЭРЭЛ